

**БУЛГАН АЙМГИЙН 2023 ОНЫ 9 САРЫН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2023-10-06

Булган

2023 оны 9 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **48,6** тэрбум төгрөг буюу 97,6 хувийн, нийт зарлага **42,3** тэрбум төгрөг буюу 72,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

**1. Төсвийн орлого**

Нийт орлого ба тусламжийн дүн **48,6** тэрбум төгрөг буюу **97.6** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 14,6 тэрбум төгрөг буюу 42,8 хувь, урсгал орлого 9,5 тэрбум төгрөгөөр буюу 37,6 хувиар өссөн байна. Урсгал орлогын гүйцэтгэл **34,8** тэрбум төгрөг буюу **96,3** хувь байна.

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт /ӨО-ны мөн үетэй харьцуулсан/	
		жилээр	тайлант үе /өссөн дүнгээр/		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	34,056.1	72,971.8	49,823.1	48,627.5	1,195.6	97.6	14,571.4	142.8
Урсгал орлого	25,157.3	53,102.1	36,169.2	34,820.3	1,348.9	96.3	9,663.0	138.4
Татварын орлого	22,323.8	45,794.2	31,157.1	31,805.8	(648.7)	102.1	9,482.0	142.5
Татварын бус орлого	2,833.5	7,307.9	5,012.1	3,014.5	1,997.6	60.1	181.0	106.4
Хөрөнгийн орлого	177.1	50.0	20.0	33.1	(13.1)	165.5	(144.0)	18.7
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилж	8,721.7	19,819.7	13,633.9	13,774.2	(140.3)	101.0	5,052.5	157.9
ОНХНСангаас шилжүүлсэн орлого	4,263.6	9,321.7	6,504.0	6,219.4	284.6	95.6	1,955.8	145.9
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4,458.1	10,497.9	7,129.9	7,554.8	(424.9)	106.0	3,096.7	169.5

Нийт орлогын 28,3 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 65.4 хувийг татварын орлого, 6,3 хувийг татварын бус орлого эзэлж байна. Үүнээс ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 19,6 тэрбум төгрөг буюу татварын орлогын 61,8 хувийг бүрдүүлсэн байна.

Сумдын хувьд төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **16,0** тэрбум төгрөг буюу **97,3** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төгрөгөөр)

д/д	Сумын нэр	2023 он төлөв.	2023 он 9 сар төлөв.	2023 он 9 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	434.3	330.2	254.7	75.5	77.1
2	Баяннуур	369.2	265.9	232.3	33.6	87.4
3	Бугат	396.4	203.2	196.5	6.7	96.7
4	Булган	5300.3	3569.4	3964.2	-394.8	111.1
5	Бүрэгхангай	1418.9	1047.9	800.4	247.5	76.4
6	Гурванбулаг	482.2	282.1	283.7	-1.6	100.6
7	Дашинчилэн	485.8	279.7	260.3	19.4	93.1
8	Могод	401.6	203.4	221.6	-18.2	108.9
9	Орхон	636.6	431.9	375.3	56.6	86.9

10	Рашаант	808.5	481.6	630.1	-148.5	130.8
11	Сайхан	454.3	344.2	234.6	109.6	68.2
12	Сэлэнгэ	524.2	339.4	250.0	89.4	73.7
13	Тэшиг	825.5	434.2	535.6	-101.4	123.4
14	Хангал	3508.9	2677.9	2464.5	213.4	92.0
15	Хишиг-Ёндер	467.8	227.6	273.0	-45.4	119.9
16	Хутаг-Ёндер	1081.0	697.5	599.2	98.3	85.9
17	Хялганат	451.7	311.4	385.7	-74.3	123.9
	<b>СУМЫН ДҮН</b>	<b>18,047.2</b>	<b>12,127.5</b>	<b>11,961.7</b>	<b>165.8</b>	<b>98.6</b>
18	Аймгийн орлого	31,512.7	21,038.1	21,090.4	-52.3	100.2
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>49,559.9</b>	<b>33,165.6</b>	<b>33,052.1</b>	<b>113.5</b>	<b>99.7</b>

Аймгийн дүнгээр авч үзвэл хувь хүний орлогын албан татвар, хадгаламжийн хүүгийн орлого, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын дуудлага худалдааны орлого, ус рашааны нөөц ашигласны төлбөр, хөрөнгө борлуулсны орлого биелжээ. Булган, Гурванбулаг, Могод, Рашаант, Тэшиг, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоны татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна.

- Аймгийн төсвийн орлогын хувьд цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын төлбөрийн өмнөх онуудын дутууг аймгийн төсөвт төвлөрүүлсэн нь гүйцэтгэлд нөлөөлж байна. Аж ахуйн нэгжүүд хуулийн дагуу хөнгөлөлт эдлэх зорилгоор жилийн татвараа урьдчилан төлсөн нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөө давж биелэхэд нөлөөлжээ. Засгийн газрын тогтоолоор усны хувь хэмжээ өөрчлөгдсөнөөс шалтгаалан үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого давж биелсэн байна.
- Сумдын хувьд нийт дүнгээр цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлого, хөрөнгийн орлого, үйл ажиллагааны орлого, шууд бус орлого, улсын тэмдэгтийн хураамж, үл хөдлөх хөрөнгийн албан татвар биелсэн байна.

## 2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **42,274.2** сая төгрөг буюу **72,3** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **36,637.3** сая төгрөг буюу **70,1** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **5,636.9** сая төгрөг буюу **90.1** хувь байна.

Аймгийн Авто замын сангийн гүйцэтгэл 609,4 сая төгрөг буюу 55,0%, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 5,486.1 сая төгрөг буюу 75,9%, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл 2,268.8 сая төгрөг буюу 68,7%, Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 3,201.4 сая төгрөг буюу 61,6% байна.

## 3. Төсвийн өглөг, авлага

Нийт өр **22,4** сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5,6 сая төгрөгөөр, өмнөх сартай харьцуулбал 1,3 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Улсын төсвийн байгууллагууд дээр тогтмол зардлын өр үүсэж байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС